ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 09 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

"Хөдөө аж ахуйн бирж" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-ийн 4.13, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолоор батлагдсан "2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт"-ын 11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Хөдөө аж ахуйн бирж" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт 397,830,000 ширхэг зарласан хувьцаанаас төрийн эзэмшлийн хувьцааг 34 хувь байх хэмжээнд хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.

2."Хөдөө аж ахуйн бирж" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа нэмж гаргах ажлыг үе шаттайгаар холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Э.Сумъяа), компанийн гүйцэтгэх захирал Х.Баатар нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн хорооны 2015 оны "Хөдөө аж ахуйн бирж төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нэмж гаргасан хувьцааг худалдах" тухай 699 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

0001485

D:\Huraldaanii material\2018 on\2018.01.09\togtool\01docx